



НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18.1.5 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Хүүхэд хамгааллын тухай тухай хуулийн 36 дугаар зүйл, 44 дүгээр зүйл, 45 дугаар зүйл, 46 дугаар зүйлүүдийг тус тус үндэслэн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит V хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, шаардлагатай холбон зуучлах үйлчилгээг үзүүлэх, аюултай нөхцөл байдалд орсон хүүхдэд шуурхай тусламжийн үйлчилгээг үзүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий хороодын Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2.Хамтарсан багийн үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтийг ханган улирал бүр тайлагнан ажиллахыг Хамтарсан багт, Хамтарсан багийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөмж өгч ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэст тус тус үүрэг болгосугай.

3.Уг тогтоол батлагдсантай холбогдуулан Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны А/40 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ч.БАТ-ОРГИЛ

Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2025 оны 06 дугаар сарын 24-ний
өдрийн 06 дугаар тогтоолын хавсралт



ХОРООДЫН ХАМТАРСАН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Хамтарсан багийн ахлагч:

Хорооны Засаг дарга

Гишүүд:

Өрхийн эмч

Сургуулийн Нийгмийн ажилтан

Цагдаагийн алба хаагч

Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал
хариуцсан мэргэжилтэн

Хөгжлийн нийгмийн ажилтан

Төрийн бус байгууллагын төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан